

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАТЫН ГАЗРЫН ӨМНӨД БҮС ДЭХ ГАЗРЫН
НАЙМДУГААР САРД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН
/2019.07.26-2019.08.25/

2019 оны 08 дугаар сарын 26

Даланзадгад сум

Гадаадын иргэн, харьяатын газрын Өмнөд бүс дэх газар нь холбогдох хууль, дүрэм, журмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон 2019 оны 07 дугаар сарын 26-ны өдрөөс 2019 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн хооронд дараах ажлыг хийж гүйцэтгэлээ.

Нэг. Виз, зөвшөөрлийн үйл ажиллагааны хүрээнд:
Виз олголтын талаар:

1.1 Гадаадын иргэн, харьяатын газрын Өмнөд бүс дэх газар нь холбогдох хууль, дүрэм, журмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон 2019 оны 07 дугаар сарын 26-ны өдрөөс 2019 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн хооронд дараах ажлыг хийж гүйцэтгэлээ.

Тайлант хугацаанд “Монгол Улсын виз олгох журам”-ын дагуу виз олгоход шаардлагатай бичиг баримтыг биедээ авч явсан БНХАУ-ын нийт 11 иргэнд зохих ангиллын визийг олгож төлбөрийг төрийн санд төвлөрүүлэн ажилласан.

Үүнд:

- HG /single-re-entry/-6
- Визийн шилжүүлэг-5

Нийт 11 гадаадын иргэнд виз олгож, тэмдэгтийн хураамжийн 700.000 /долоон зуун мянга/ төгрөгийг Өмнөговь аймгийн Татварын газрын дансанд тус тус тушаалган ажилласан болно.

Тайлант хугацаанд Гашуунсухайт, Шивээхүрэн боомтоор зорчсон БНХАУ-ын нийт 3541 иргэний баримт бичиг болон хөдөлгөөнд хяналт тавьж ажилласан. Үүнд:

Орох чиглэлд:1638

Гарах чиглэлд:1903

Гашуунсухайт боомт

- Орох чиглэл -1257
- Гарах чиглэл-1348

Шивээхүрэн боомт

- Орох чиглэл-381
- Гарах чиглэл-551

1.2 Түр ирэгчийн бүртгэл, хасалт:

Тайлант хугацаанд 35 гадаадын иргэнд түр ирэгчийн бүртгэл, 2 иргэний хасалт хийж ажилласан байна.

1.3 ХОНЗҮ-ээр зорчигч гадаад иргэдийн хяналтын талаар:

Тайлант хугацаанд хил орчмын нутагт зорчих нэг болон олон удаагийн үнэмлэхтэй БНХАУ-ын 87 иргэнийг бүртгэж, 93 иргэнд хасалт хийж тухайн

иргэдийн шилжилт хөдөлгөөн, Монгол Улсад байх хугацаанд хяналт тавьж ажилласан.

1.4 Монгол Улсын хилээр оруулаагүй буцаасан гадаадын иргэдийн талаар:

Гашуунсухайт, Шивээхүрэн авто замын боомтоор “Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль”-ийн 11 дүгээр зүйлийн 11.6 дахь заалт, мөн хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.6, “Монгол Улсын виз олгох журам”-ын 3.9 дэх заалтыг тус тус үндэслэн, ярилцлага хийж БНХАУ-ын 14 иргэнийг Монгол Улсын хилээр оруулаагүй буцаасан.

1.5 Гарын хурууны хээ, фото зураг авсан талаар:

Тайлант хугацаанд Монгол Улсад хөдөлмөр эрхлэхээр ирсэн болон албадан гаргагдсан БНХАУ-ын 24 иргэний гарын хурууны хээ болон фото зургийг авч төвд хүргүүлсэн.

1.6 Торгуулийн арга хэмжээ авагдсан талаар:

Гашуунсухайт боомтын гарах хөдөлгөөний чиглэлд 2019 оны 08 дугаар сарын 08, 16-ны өдрүүдэд бичиг баримтын шалгалт хийх явцад оршин суух хугацаа хэтрүүлсэн ӨАБНУ-ын 1 иргэнийг илрүүлж Зөрчлийн тухай хуулийн 16.2 дугаар зүйлийн 3.2-т заасныг үндэслэн 40 тооцооны нэгж буюу 40.000 төгрөг, нутаг дэвсгэрт хөдөлмөр эрхлэх журам зөрчсөн БНХАУ-ын 1 иргэнийг илрүүлж мөн хуулийн 16.2 дугаар зүйлийн 1.4 дэх заалтын дагуу 100 тооцооны нэгж буюу 100.000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч улсын төсөвт нийт 140.000 төгрөг төвлөрүүлэн, зөрчлийг арилгаж ажилласан байна.

1.7 Албадан гаргасан талаар:

Зөрчлийн тухай хуулийн 16.2 дугаар зүйлийн 1.4-т заасныг үндэслэн нутаг дэвсгэрт хөдөлмөр эрхлэх журам зөрчсөн БНХАУ-ын 1 иргэнийг “Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль”-ийн 37 дугаар зүйлийн 37.1.7, “Гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах болон Монгол Улсад дахин оруулахгүй байх хугацаа тогтоох журам”-ын 3.7 дугаар зүйл, байгууллагын даргын энэ оны 08 дугаар сарын 16-ны өдрийн А/297 дугаар тушаалыг тус тус үндэслэн Монгол Улсад гурван жилийн хугацаанд дахин орж ирэх эрхийг хасч, албадан гаргасан болно.

Байгууллагын даргын 2019 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 03 дугаар албан даалгаврын хүрээнд:

Тайлант хугацаанд Зөрчлийн тухай хуулийн 16.2 дугаар зүйлийн 3.2 буюу оршин суух хугацаа хэтрүүлсэн ӨАБНУ-ын 1 иргэн, мөн хуулийн 16.2 дугаар зүйлийн 1.4-т заасны дагуу нутаг дэвсгэрт хөдөлмөр эрхлэх журам зөрчсөн БНХАУ-ын 1 иргэнийг тус тус торгож, хасалтыг хугацаанд нь хийж хилээр гаргасан.

Өмнөд бүс дэх газрын даргын энэ оны 03 дугаар сарын 25-ны өдөр баталсан “Өдөр тутмын үйл ажиллагаанд мөрдөх заавар батлах тухай” тушаалын дагуу харьяа нутаг дэвсгэрт бүртгэлтэй гадаад иргэдийн шилжилт хөдөлгөөнд хяналт тавин ажилласан болно.

Хоёр. Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд

Тус газар нь нийт 23 албан хаагчийн орон тоотойгоор батлагдсан бөгөөд тайлант хугацаанд 18 албан хаагчийн орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж байна. 2019 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар 13 албан хаагч батлагдсан хуваарийн дагуу ээлжийн амралт эдэлсэн байна.

Хүний нөөцийн програмд 18 албан хаагчийн цалин, төрийн албанд ажилласан жилийн нэмэгдэл, зэрэг дэв, ур чадварын нэмэгдэл зэрэг мэдээллийг тухай бүр нь шивж ажилласан.

Байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн програмд тус газарт ирсэн 83, явсан 59 албан бичиг, 15 өргөдлийг скайнердан бүртгэж цахим хэлбэрт шилжүүлэн ажилласан.

Тус газрын 2019 оны сургалтын төлөвлөгөөний дагуу албан хаагчдын эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлэх зорилгоор Өмнөговь аймгийн Эрүүл мэндийн газартай хамтран “Хэрхэн аз жаргалтай амьдрах вэ”, “Эрүүл зөв хооллолт” сэдвээр сургалтыг зохион байгуулан ажиллалаа. Сургалтыг Өмнөговь аймгийн Эрүүл мэндийн газрын мэргэжилтэн Н.Буян-Ундрах удирдан явуулсан бөгөөд газрын төвийн нийт 10 албан хаагч хамрагдлаа.

Гадаадын иргэн, харьяатын газрын “Удирдах ажилтан, хяналтын улсын байцаагч нарын тэргүүн туршлага солилцох цугларалт”-ыг 2019 оны 09 дүгээр сарын 03-07-ны өдрүүдэд Өмнөговь аймагт зохион байгуулахаар ажиллаж бэлтгэл ажлыг ханган байна. Тухайлбал, цугларалт зохион байгуулагдах “Говь дисковери тур” ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулах, гар бөмбөгийн элсэн талбайн элс буулгах, стандартын дагуу талбайг бэлтгэх ажлуудыг хийж гүйцэтгэн ажиллалаа.

2.1.Өргөдөл, гомдлын мэдээ

- Бүртгэсэн өргөдөл, гомдлын тоо /Хүлээн авсан/- 3
- Шийдвэрлэсэн өргөдөл, гомдлын тоо-3
- Шилжүүлсэн өргөдөл, гомдлын тоо-0
- Шийдвэрлэлтийн шатанд байгаа болон хугацаа сунгасан өргөдөл, гомдлын тоо-0
- Баримт бичиг боловсруулалтын хүрээнд /Тушаал-0/
- Төвөөс ирсэн бичиг-0
- Төв газарт явуулсан бичиг /албан тоот-0, илтгэх хуудас-0/
- Бусад байгууллагад хүргүүлсэн бичиг /албан тоот-4/
- Бусад байгууллагаас ирсэн бичиг-4
- Боомт орон нутагт явуулсан дотоод албан бичиг-0

2.2.Санхүү, хангалт үйлчилгээний чиглэлээр:

Энэ оны 08 дугаар сард нийт 18 албан хаагчийн цалинд өссөн дүнгээр 13,119,918.42 төгрөгийг олгож, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал болох байрны түрээсийн зардалд 1,150,000 төгрөг, цахилгааны төлбөр 280,660 төгрөг, шуудангийн зардал 201,622 төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 474,500 хичээл үйлдвэрлэлийн зардалд 1,248,000 төгрөгийн гүйлгээ хийж Өмнөговь аймгийн Төрийн сангаар баталгаажуулан гүйлгээ хийж ажилласан байна.

Тус газрын 2019 оны 06 дугаар сарын шилэн дансны мэдээллийг цахим сайтад байршуулж тоон мэдээг дараа сарын 02-ны дотор холбогдох нэгжид хүргүүлж ажилласан.

2.3.Мэдээлэл технологийн чиглэлээр:

Газрын хэмжээнд сүлжээний хэвийн байдлыг ханган, бүсийн хэмжээнд гарсан 2 эвдрэл, гэмтлийг тухай бүр нь засч сайжруулан хэвийн үйл ажиллагаанд оруулан ажилласан.

Мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллах үүднээс байгууллагын цахим хуудсанд тус газрын 2019 оны 06 дугаар сарын төлөвлөгөөний биелэлт, тайлан, өргөдөл, гомдлын мэдээ, үйл ажиллагааны мэдээ мэдээллийг тухай бүр байршуулж олон нийтийг мэдээллээр ханган ажилласан байна.

2.4. Хилийн боомтын үндэсний зөвлөлийн 2019 оны 01 дүгээр зөвлөмжийн талаар:

“Хөгжлийн хөтөч дэд бүтэц” төслийн “Хилийн боомт” дэд төслийн хүрээнд Гашуунсухайт боомтод энэ оны 04 дүгээр сарын 25-26-ны өдөр түр нүүлгэн шилжүүлэлтийн үед албан хаагчдын амьдрах байр, албаны үйл ажиллагааг хэвийн тасралтгүй явуулах талаар хурлыг зохион байгуулсан бөгөөд уг хуралд тус газрын виз, зөвшөөрлийн ахлах мэргэжилтэн Ц.Түвшинтүшиг, хяналтын улсын байцаагч С.Мөнхтүвшин нар оролцсон болно. Тайлант хугацаанд уг зөвлөмжийн дагуу нүүлгэн шилжүүлэлтийн болон бүтээн байгуулалтын ажил хийгдээгүй, боомтын үйл ажиллагаа хэвийн үргэлжилж байгаа бөгөөд тус газраас нүүлгэн шилжүүлэлтийн ажлын бэлтгэл байдлыг ханган ажиллаж байна.

ӨМНӨД БҮС ДЭХ ГАЗАР